



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/147

Булган сум

Аймгийн аюулгүйн нөөцийн  
өвс, тэжээлийг худалдан борлуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, аймгийн Онцгой комиссын 2023 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн 01 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн аюулгүйн нөөцөд бэлтгэсэн өвс, тэжээлийг сумдад тараах хуваарийг хавсралтаар баталж, 1 боодол өвсний үнийг 4,000 (дөрвөн мянга) төгрөг, 1 тонн тэжээлийн үнийг 550,000 (таван зуун тавин мянга) төгрөгөөр худалдан борлуулахыг аймгийн "Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй" ОНӨХХК-ийн захирал (Ш.Өлзийхутаг)-д зөвшөөрсүгэй.

2. Худалдан борлуулсан өвс, тэжээлийн үнийг Мал хамгаалах сангийн 100040051410 дансанд төвлөрүүлэхийг аймгийн "Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй" ОНӨХХК-ийн захирал (Ш.Өлзийхутаг)-д үүрэг болгосугай.

3. Дээрх ажилд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ч.Амгалан)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2023. оны  
01. дүгээр сарын 20.-ний өдрийн А/37 дугаар  
захирамжийн хавсралт

**АЙМГИЙН НӨӨЦИЙН ТЭЖЭЭЛИЙГ СУМДАД ОЛГОХ ХУВААРЬ**

Д/д	Сумын нэр	Олгох тэжээл (тн)	Нэг тонны үнэлгээ (төгрөг)	Нийт үнэ
1	2	3	4	5
1	Баяннуур	8 тн	550,000	4,400,000
2	Дашинчилэн	5 тн		2,750,000
3	Рашаант	5 тн		2,750,000
4	Гурванбулаг	5 тн		2,750,000
5	Могод	5 тн		2,750,000
6	<b>Бүгд дүн</b>	<b>28 тн</b>		<b>15,400,000</b>

**АЙМГИЙН НӨӨЦИЙН ӨВСИЙГ СУМДАД ОЛГОХ ХУВААРЬ**

Д/д	Сумын нэр	Олгох өвс (Боодол)*	Нэг боодол өвсний үнэ (төгрөг)	Нийт үнэ
1	2	3	4	5
1	Баян-Агт	1000	4,000	4,000,000
2	Баяннуур	2000		8,000,000
3	Бүрэгхангай	1000		4,000,000
4	Гурванбулаг	1500		6,000,000
5	Дашинчилэн	1000		4,000,000
6	Могод	1000		4,000,000
7	Сайхан	1000		4,000,000
8	<b>Бүгд дүн</b>	<b>8500</b>		